

COVID-19-ийн нөлөөгөөр Японд дахин нэвтрэх зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд Япон улсын хилээр нэвтрэн ороход бэрхшээлтэй байгаа байнгын оршин суугчдад зориулав

COVID-19-ийн нөлөөгөөр Японд дахин нэвтрэх зөвшөөрөл болон дахин нэвтрүүлэх тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд Япон улсын хилээр нэвтрэн ороход бэрхшээлтэй байгаа байнгын оршин суугч дараахь аргаар Япон улсад дахин нэвтрэх боломжтой (*1) тул, оршин суугаа газрын Японы элчин сайдын яам эсвэл консулын газартай зөвлөлдөнө үү.

(1) Дахин нэвтрэх зөвшөөрлийн хугацаа дууссан, хүчинтэй хугацаанд Япон улсын хилээр нэвтрэн ороход бэрхшээлтэй байгаа бол;

Оршин суугаа газрын Японы элчин сайдын яам эсвэл консулын газарт дахин нэвтрэх зөвшөөрлийн хугацааг сунгах тохиолдол бий.

[Хүчинтэй байх хугацаа дууссан өдрөөс 1 жилийн хугацаагаар сунгана.]

Хэрэв дахин нэвтрэх зөвшөөрлийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол, хүчинтэй байх хугацаандаа багтааж Япон руу дахин орно уу. Хэрэв сунгаж чадахгүй бол Япон руу нэвтрэх арга (2)-г ашиглана уу.

(2) Дахин нэвтрүүлэх тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа дууссан тохиолдолд, (арга (1)-г ашиглах боломжгүй тохиолдлыг оруулна.)

[Хилээр дахин нэвтрэх зөвшөөрөл эсвэл дахин нэвтрүүлэх тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа нь 2020 оны 1-р сарын 1-нээс эхлэн **2023 оны 4-р сарын 30-ны өдөр** хүртэлх хугацаанд дуусах хүмүүс хамрагдана.]

2023 оны 4-р сарын 30-ны өдөр хүртэл оршин суугаа газрын Япон улсын элчин сайдын яам эсвэл консулын газарт “Япон улсад цагаачлагч”-ийн визээ мэдүүлнэ үү.

Виз гарч Япон улсын хилээр нэвтрэх үед нисэх онгоцны буудал дээр “Байнгын оршин суугч”статусаа шинээр мэдүүлэн нэвтрэх боломжтой.

※1 ① болон ② явцаар мэдүүлэхэд шаардагдах бичиг баримтын тухай дараах Гадаад хэргийн яамны цахим хуудаснаас шалгана уу.

https://www.mofa.go.jp/about/emb_cons/mofaserv.html(Гадаад хэргийн яамны цахим хуудасны холбоос)

※2 Энэхүү арга хэмжээний нөхцөл хангаж байгаа хүн тус арга бус доорх ① болон ②-т заасан “Байнгын оршин суугч”-аас бусад төрлийн оршин суух зөвшөөрлөөр Япон улсын хилээр нэвтрэн орсон бол, нэвтэрсэн өдрөөс хойш 6 сарын дотор байнгын оршин суух зөвшөөрлийн мэдүүлэг өгснөөр, тус мэдүүлэг, өргөдөл([Лавлагааны маягт 1](#)), өмнөх оршин суух үнэмлэхийн хуулбараар хянан шалгуулах боломжтой. (Нэмэлт бичиг баримтууд шаардагдах магадлалтай.)

① 2023 оны 10-р сарын 31-ний өдөр гэхэд мэдүүлсэн визийн хүчинтэй хугацаанд “Байнгын оршин суугч”-аас бусад төрлийн оршин суух зөвшөөрлөөр Япон улсын хилээр нэвтэрсэн тохиолдолд

② Визээ авахгүйгээр 2023 оны 10-р сарын 31-ний өдөр гэхэд “Байнгын оршин суугч”-аас бусад төрлийн оршин суух зөвшөөрлөөр Япон улсын хилээр нэвтэрсэн тохиолдол

Харин Япон улсын хилээр нэвтэрсний дараа байнгын оршин суух зөвшөөрөл авах тохиолдолд 1 хүн 8000 иений төлбөр төлөх шаардлагатай болохыг анхаарна уу.

Мөн хилээр нэвтрэн орсноос хойш 6 сараас дээш хугацааны дараа байнгын оршин суух зөвшөөрлийн хүсэлт гаргах бол, энгийн байнгын оршин суух зөвшөөрлийн хүсэлт гаргахтай адил нотолгооны баримт шаардагдахыг анхаарна уу.

Байнгын оршин суух зөвшөөрлийг авч Япон улсад дунд болон урт хугацаагаар оршин суугч болмогц хот, дүүргийн захиргаанд хандан оршин суугаа хаягаа бүртгүүлнэ үү.